

СҮМБЭ ХАМБА ИШБАЛЖИРЫН УТГА ЗОХИОЛЫН ТУУРВИЛ ЗҮЙН ОНЦЛОГ

Шү Лин, доктор, ӨМНШУХ

Аннотация: Постредством детального исследования литературной концепции творчества монгольского национально известного питателя и теоретика Сумбэ Хамбо Ишбалжира, были сформированы основные направления, прослеживаемые в его работах, стиль написания, необходимость и значение творчества и многих других сторон его работ. В данной статье выдвинуты специфические особенности сочинения и составлена теоретическая системы сочинительства.

Он не только единственный писатель, но и первый, кто смог установить закономерность системы теоретических принципов литераторства. Сумбэ Хамбо Ишбалжир, во время адаптации индийского «Зеркало поэзии Данина», не просто скопировал книгу, а адаптировал ее методом отбора и фильтрации, основываясь на собственном мышлении, таким образом, создал совершенно новое литературное направление.

Так же эта текстовая инструкция, отражает главную тенденцию истинной сущности религии, учении и концепции о необходимости праведном образе жизни людей. Истинная сущность сочинения, основывается на особенностях монгольского я языка, словарном составе языка, и имеет установленные нормы. В процессе адаптирования, написания, следует избегать использования разного рода лишних слов, но использовать необходимые слова, что бы добиться совершенности смысла. Эти нормы приемлемы для адаптированных работ, поэзии, писем и т.д., влияет на писательство в целом. Во время исследования работ Сумбэ Хамбо Ишбалжира мы изучили «сущность мастерства адаптации, нормы адаптирования, совершенство смысла и истины, созидания красоты, создании девяти правил танца, насущная необходимость составления биографий, беспорочная стилистика» и др. особенности сторон его работ.

Түлхүүр үг: Бичвэр зүй, утга санаа, чиг хандлага

Удиртгал

Тус өгүүлэлд монголын алдарт зохиолч Сүмбэ хамба Ишбалжирын утга зохиолын туурвил зүйн үзэл баримтлалыг задлан шинжлэхийн зэрэгцээ түүний зохиолын агуулга, үзэл санаа, зохиол бүтээлээ туурвих арга хэв маяг, туурвил зүйн ач холбогдол зэрэг асуудлыг түүний бий болгосон туурвихуйн ухааны онолын тогтолцоог цогцлоосон талаар өгүүлэх болно.

Үндсэн хэсэг

Сүмбэ хамба Ишбалжир нь зохиолч төдийгүй утга зохиолын онолын салбарт өөрийн гэсэн орон зайг цогцлоосон нэгэн билээ. Тэрээр гучин гурван насандаа “Зохист аялгууны толиос номлосон чимгүүдийн үлгэр өгүүлэхүй одон мичдийн үзэсгэлэнт эрихэс ба илт өгүүлэхүй нэрийн товч хураангуй чандманийн уншлага хэмээгдэх оршбай” /1736 он/ хэмээн ном бичсэн нь монгол үндэстний дотроос хамгийн анхны шүлэг зүйн онолын тусгай бүтээл болсон билээ. Энэхүү бүтээлээс түүний утга зохиолын системт бичвэрзүйг өөрийн гэсэн онцлог туурвих хэв маягийг харж болно. Тус бүтээл бичигдэх тэр

цагт утга зохиолын онолч Фашсан хараахан мэндлээгүй үе буюу түүнээс хойш зуун жилийн дараа их зохиолч Инжинаш мэндэлсэн байна. Даруй утга зохиолын онолч Хасбу мэндлэхээс өмнө тавь, жаран жилийн өмнө тэрээр зохиол бүтээлээ туурвиж байжээ. Тэрээр олон бүтээлдээ зохист аялгуу буюу утга зохиол гэж юу? болох, түүний агуулга утга зохиолын ур чадвар, зорилго ба онцлог шинж, утга зохиолыг хэрхэн туурвих зэрэг онолын асуудлыг дэвшүүлж түүндээ өөрийн гэсэн санал дүгнэлт өгч чадсан юм. Тэрээр ингэж өөрийн онол, үзэл баримтлалын тогтолцоог бүрэлдүүлсэн болно. Энэ нь монголчуудын утга зохиолын онолын өвийг улам төгөлдөржүүлсэн төдийгүй дорно дахины утга зохиолын онолын санд өөрийн хувь нэмрээ оруулж чадсаныг доорх баримтаас харж болно.

Ишбалжир нь сайтар тунгаан боловсруулсны эцэст зохиол бүтээлээ туурвидаг зохиолч, утга зохиолын онолч билээ. Тэрээр Энэтхэгээс уламжлан ирсэн Дандины “Зохист аялгууны толь”-д бусад хүмүүсийн тайлбар зохиолуудыг дагаж тайлбар бичсэнгүй, харин өөрийн үзэл санааг

тусгаж онолын бүтээл туурвиснаас гадна, өөрийн утга зохиолын онолын байр сууриа цогцлоож чадсан эрдэмтэн болжээ. Тэрээр Монголчуудын дундаас хамгийн анхны номлохуй, тэмцэхүй, туурвихуйн онолыг бичсэн хүн. Сажа Бандида Гунгаажалцан “Мэргэд орохын хаалга хэмээгдэх оршвой” гэх бүтээл туурвиж, номлохуй тэмцэхүй, туурвихуйн нэг системт онолыг дурдан Төвөдийн шүлэг зүйн онолын суурь ба номлохуй, тэмцэхүй туурвихуйн онолын суурийг цогцлоосон билээ. Ишбалжир түүнийг уламжлан хөгжүүлж, өөрийн онцлог бүхий үзэл баримтлалаа дэвшүүлснээр, Монголчуудын дотор зохист аялгууны онол ба туурвихуйн онолыг хамтад нь хөгжүүлсэн байна.

Ишбалжирын утга зохиолын тухай онол үзэл баримтлалын дотор, туурвихуйн тухай үзэл баримтлал нь зохих хувь нэмрийг оруулсан тул түүний онолын тогтолцоог улам дэлгэрэнгүүлжээ. Тэрээр зохиогчийн намба төрх, зохион туурвих зарчим, бодитой туурвих шаардлага зэргийг дурдаж, туурвихуйн онолын системээ цогцлоосон болно.

Нэг. Туурвигчийн чанар чансааны тухай

Ишбалжир “Номын явдлын өчүүхэн хураангуй, сайн галавын гэтэлгэх мөр хэмээгдэх оршвой” бүтээлдээ туурвихуйн тухай номлохдоо туурвигчийн бүрэлдүүлбээс зохих нөхцөлийг дурджээ. “Зохист аялгууны голууд алимэд”-ийг туурвихуйд ч оюун билиг, олонтоо сонсох, хичээл шамдал төгөлдөр ба онцгойлон Төвд зохионгуй мэтэд урьд эр, эм саармаг үсгийн шинжлэл тэргүүтэнд шүтэх угтвар үсэг ба дагавар алиныг олох ба долоон тийн ялгал ба бусад үгсийн нэрийн зүйл тоолол ба нэр үгсийн хувь хүртээл ба, алимэдэд хэр мэт үйл үйлдэх ба чимэг тэргүүтнийг мэргэдээр суралцах хэрэгтэй” (Ишбалжир, зүүлт: 1.6 дээд) гэсэн бичвэрт зохих хамгийн наад захын нөхцөлийг дурдсан байна.

Оюун билиг буюу төрөлх самбаа, олонтоо сонсох буюу олон эрдэм сурсан, хичээл шамдал, оролдлого чармайлт энэ гурав бол Дандины дурдсан зохист аялгуу туурвихад хэрэгсэх гурван зүйлийн шаардлага мөн. Төрөлх хурц мэргэн оюун билиг байвал нэн сайн, хэрэв үгүй бол бусад хоёр нөхцөл болох олонтоо сонсох ба хичээл шамдал байсан ч туурвиж үл болно.

Энэ бол хүний хичээл зүтгэлийг нотолсон зүйл мөн. Ишбалжир энэ гурван нөхцөлийг улам төгөлдөржүүлэх үүднээс нэгэн цогц ухаан болгон өгүүлжээ. Үүнийг Ишбалжирын “Гурван

үндсэн нөхцөл” гэж болно. Ишбалжирын дурдсан хоёрдугаар нөхцөл гэвэл тоон ухаан буюу хэлзүй, үгсийн сангийн мэдлэгийг багтаасан хэлний талын нөхцөл шаардлага болно. Үүнд: эр, эм, саармаг үсгийн шинжлэл, угтвар, дагавар, тийн ялгал, эрхэс нэрийн төрөл зүйл, үйл үгийн хэрэглээг багтаасан үгсийн сан ба хэлзүйн ай зэргийг нэрлэн дурджээ. Энэ нь утга зохиол бол хэлний урлаг болох тул хэлний мэдлэг боловсролыг чухалчилсан байна. Гуравдугаар нөхцөл гэвэл зохист аялгууны чимгийн арга онолыг суралцаж эзэмших болно. Үүнд: зохист аялгууны арван эрдэм, арван гэм, утгын гучин таван чимэг, хос төгөлдөр чимэг, үйлдэхүеэ бэрх чимэг, эгшиг магадлах, үхрийн шээсэн мөрийн шүлэг, Самандабадраагийн шүлэг зэргийг багтаасан дууны чимэг, нууц үгсийн чимэг зэргийг багтаана. Энэ нь зохист аялгуу буюу утга зохиол туурвигчид бол зохих таван нөхцөл болно.

“Сүмба хамба Занаашир Бхутиваар олон их голуудаас хурааснуудын гарчиг “Их мэргэд номлохуй тэмцэхүй туурвихуй ба сайн мэргэн шидтэний эрдэм төгөлдөр бөгөөд хэлбийхгүй мушгиан хир өчүүхэн ч эс байхуудад төрөхийн дээд ба баясал төрүүлэх тахил машинд арилсан эс болбоос, бас тэдгээрийн хойно орохын тусад олон сонссон төгөлдөрүүдийн шинжлэл нь урьд болой” (Ишбалжир, зүүлт: 2. 4 дээд-4 доод) гэж, туурвигчийн олон сонсохыг чухалчилсан байжээ.

Хэрвээ эрдэмтэн мэргэд туурвигчид сайн мэргэн шидтэний эрдэм төгөлдөр болох ба хэлбийхгүй мушгиан хиргүй болох гэвэл, анхлан олон удаа сонсож шинжлэх хэрэгтэй. Нөгөө талаар туурвигч нь бас сайн мэргэн шидтэний эрдэм төгөлдөр байх хэрэгтэй ба хэлбийхгүй мушгиан хирээр халдварласангүй байх хэрэгтэй гэсэн үзэл агуулж байна хэмээн үзэж болно. Тэрээр “Сүмбэ хамба Занаашир Бхутиваар олон их голуудаас хурааснуудын гарчиг”-т туурвигчид байваас зохих гурван зүйлийн нөхцөл шаардлага дурдав. Энэ нь бурхны шашны туурвигчид тавьсан онцгой шаардлага болно.

Тэр “сайтар арилсан шастирын зохиогч нь эрдэм бурхандаа барьж зарлигийн соёрхлыг хүртэх ба ухааны орнуудад мэргэших ба бурхныг барих бөгөөд тасралгүй үндсэн увдис лугаа төгссөн гурав буюу хамаг наад захдаа тус тус, дур дур төгссөн байх хэрэгтэй болой.” (Ишбалжир, зүүлт: 3. х.1 дээд) гэж машинд зөв ариун шастир зохиол туурвих зохиогчийн заавал бүрэлдүүлэх чухалтай гурван нөхцөл бол эрдэм бурхныг дагаж зарлиг соёрхол хүртэх, ухааны орон бүхэнд мэргэшсэн,

бурхны шашныг баримтлан үндэсний уддисыг олж төгссөн гурван байх болно. Үүнийг бас бурхны шашинтнуудын уран зохиол туурвигсдад тавьсан шаардлага гэж үзэж болно. Бурхны шашинтнууд ямар нэгэн онол буюу эш номлохдоо заавал эрдэм бурхан буюу дээд багшийн эрх соёрхлыг хүртэх хэрэгтэй, иш лүнг хүртсэнгүйгээр уддис буюу эрдэм хүлээж болохгүй.

Энэ бол бурхны шашинтнуудад тавьсан онцгой шаардлага мөн. Энд бас таван ухаанд мэргэших бол бурхны шашинтан туурвигчдын бүрэлдүүлбээс зохих чанар чансаа мөн гэж дурджээ. Сажа бандида Гунгаажалсан “Мэргэд орохын хаалга”-даа мэргэд болохын хаалга бол даруй ухааны оронд мэргэших хэрэгтэй гэж дурдсан байдаг.

Ишбалжир бас “Гурван эрдэнийн үгний найруулга”-ын

“Ухааны нарийн мөрийг ялгахын тийн шинжлэл ба

Онол ёсны сургаалаар ургасан анхааран авалт ба

Үгсийн найруулгын ёсонд мэргэшсэн хэлний цогт

Үлэмж хүний ертөнц үүнээ гурван тийн эрдэнэ харагдмуй.” (Ишбалжир, зүүлт: 4. х.1 дээд) гэсэн үгийг эшлэн өгүүлж туурвигч нь энэ гурван нөхцөлийг бүрэлдүүлбээс зохино гэжээ. Энэ гурван нөхцөл буюу эрдэнэ бол ухааны нарийн ялгалыг ялгаж чадах шинжлэлийн оюун байх онол ёсыг эзэмшин тогтоох үгсийн найруулгын ёсонд мэргэшсэн хэлний эрдэмтэн байх болно. Энэ нь туурвигчийн онолын чанар чансаа, гүн ухааны чанар чансаа, хэл найруулгын чанар чансааны асуудлыг хөндсөн байна.

Ишбалжир “Хамба эрдэнэ Бандида хэмээн алдаршсаны ёсыг өгүүлсэн дуу дуун баригч (чихэн)-ийн тэжээл хэмээгдэх оршвой” зохиолынхоо оршил шүлэгтээ намтар зохиол туурвих тухай өөрийн үзэл баримтлалаа ярьсныг зохиогчийн өөрийн үзэл суртлын асуудлыг хөндсөн гэж үзэж болно. Тэрээр намтар туурвигч “Дээдэд атаархаж, доордод хилэгнэх”, “өөрийгөө мандаж бусдыг муулах (доромжлох)”, “хоосон үг өгүүлэх”, “богдос буюу хутагтаар овлох”, “бүхнийг мэдэгчээр овлох”, “шашин амьтны тусын төлөө хэмээгээд өөрийн тусаа эрэх”, “хуурмагаар өгүүлэх”, “шашны сахилтай харшсан ч шашны ёсон гэж хуурмаглах”, “дөлгөөн зөөлөн хуурмаг

үгээр бусдын толгойг эргүүлэх”, “аманд ном номлож, сэтгэлд арга заль бясалгах” (Ишбалжир, зүүлт: 5. х.1-2 дээд) зэрэг нь ичгүүртэй муухай гэж шүүмжлээд, иймэрхүү ёс зүйн алдаат суртлыг тэвчих хэрэгтэй гэжээ. Энд туурвигчийн хүн чанар ёс суртахууны асуудлыг тун чухалчилсан байна. Энэ нь зохиогч туурвигчийн бүтээлтэй шууд холбогдох явдал мөн. Тиймэрүү ёс суртахууны үзлээр бичсэн намтар зохиол, бусад төрлийн зохиол ч уншигчийг мэхлэх, хуурах, муу зүг хөтлөх муу бүтээл болно.

Ишбалжир бас “(Мэргэд орохын хаалга)-аас (тангараг лугаа дурдсан үгс тэргүүтнийг номлохын тусад дэлгэрүүлэн үзүүлэх хэрэгтэй) хэмээсэн ба эс чадах билиггүй ч шамдах мэтчилэн шастирт орохын үгсийг үйлдэх болой хэмээсэн тэргүүтэн мэтээр, туурвилыг эс тэвчихийн тулд тангараг ба сонсохуйг сануулах ба омгийг орхихыг үйлдэгч дээдийн ёсон болой” (Ишбалжир, зүүлт: 6. х.64 доод) гэж туурвигчийн туурвих ур маягийн тухай өгүүлсэн байдаг.

Энд зохиол туурвигчид төрөлхөөсөө зохиол туурвих ур чадвар, хурц билиггүй ч, шамдан хичээх хэрэгтэй ба тангараг, сонсохуйг сануулахаар дэмжиж туурвилаа тэвчихгүй үргэлжлүүлэх ёс зориг өвөрлөх, омгийг орхиж даруу хичээнгүй ёс суртахуунтай болохыг шаардаж байна.

Иймээс Ишбалжирын туурвил зүйн чанар чансааны үзэл, төрөлх билиг, олныг сонссон, хичээн шамдах гэх үндсэн гурван нөхцөл, Ядам бурхны авшиг, зарлигийн соёрхол хүртэх, үндэсний уддис хүртэх зэрэг бурхны шашинтнуудын дотоод шаардлага, таван ухаанд мэргэших ба гүн ухаан эш онол эзэмшсэн гүн давхаргын шаардлага ба тохио тохиолдуулагч хэл зүй, үгсийн сангийн мэдлэг, үгсийн чимэг, үгийн найруулгад мэргэших зэрэг хэл найруулгын шаардлага, зохиогчийн хичээл чармайлтыг төв ёс суртахуун зэрэгт багтааж буй юм.

Хоёр. Туурвил зүйн ёс

Ишбалжирын "Номын явдлын өчүүхэн хураангуй"-н туурвихуйн тухай номлолд, туурвилд орохын гишүүн, бодитой бие ба орохын үйл гэх гурав буй гэж дурдаад өлзий өгүүлэх мөргөл өгүүлэх дарааллаас туурвихуй бие, хэрхэн үзэсгэлэнт туурвихуй гэмгүй туурвих туурвихуйн ач тус зэргийн тухай голчлон өгүүлсэн юм. Үүнээс гадна бусад зохиолууддаа бас хэрхэн туурвих тухай олон шаардлага дурдсан байдаг. Тэдгээрийг багцалбал яруу үзэсгэлэнт үйлдэх,

утга үнэн бөгөөд төгөлдөр байх, бүжгийн есөн дүрийг найруулах, гэмгүй найруулах зэрэг болно.

Үзэсгэлэнт үйлдэх

Ишбалжирын туурвихуйн үзэл санаа дотор яруу үзэсгэлэнт үйлдэх бол чухал нэгэн онцгой нэгэн чухал үзэл баримтлал болох юм. Энэ нь чамин үгээр чимэглэж, эгэл гүдэх үгсийг хэрэглэхийг тэвчих явдал болно.

Ишбалжираас “захидал бичиг тэргүүтний тийн агуулал, шинэ оюутны баяр хуримын үүдийг нээхүй” гэх зохиолдоо бас үгсийн найруулгыг үйлдэхэд зохист аялгуу болон илт өгүүлэхүй нэрээр чимэглэх хэрэгтэй гэсэн санааг дурдсан байв.

Тэр “ялангуяа захидал бичгийг сайнаар бичихүйд ... үгсийн найруулга зөөлөн үйлдэхүй бөгөөд Энэтхэгийн өмнөд ба дорнод тус тусын ба нийтийн утгын чимэг, дууны чимэг ба найруулга ширүүн ба нууц үг тэргүүтэн нууц үгсийн чимэг ба зохист бус нэрийг ижилхэн эс давтаж өгүүлэхийн хэрэгцээ тэргүүтэнд илт өгүүлэхүй нэрээр чимэглэж үзэсгэлэнт болгон үйлдэх хэрэгтэй тул тэдгээрийг найруулах хэрэгцээ их бөгөөтөл, тэр мэт бусаар өөрийн зорилгоор, дур дэвээр үйлдвээс мэргэдийн инээдэм шогийн орон болох болой” (Ишбалжир, зүүлт:7. х.4 дээд) гэж зохист аялгууны чимэглэх арга ба унжид нэрээр чимэглэх аргын зохист аялгуу туурвих, үгсийг найруулан чимэглэхэд үзүүлэх ур чадварыг чухалчлан өгүүлсэн бөгөөд нэрийг ижилхэн давтах зохист бус найруулга ба журам горимгүй дур тааваар зохиовоос мэргэдийн шог болно хэмээн сэрэмжлүүлсэн байдаг.

Тэрээр захидал бичиг зэрэгт эгэл гүдэг үгс хэрэглэхийг хориглож “багш, хаан, сүмийн захирагч, түшмэл, бусад мэргэд лүгээ нөхөрлөн харилцан сэтгэлдээ зохицолдуулан үйлдэх захидал үгс нь тасалсан, үргэлжилсэн, хавсарсан алимэдэд ч эгэл гүдэг үгс төдийг өргөвөөс (бичвээс), үлгэрлэвээс залуу идэр хүн дүрс үзэсгэлэнт ч өмсгөл чимэглэл лүгээ ангижраад бараадаар ичсэн мэт” (Ишбалжир, зүүлт: 8. х.4 дээд) гэж захидал бичгийг утга зохиолын чимэглэлийн үгсээр бичих хэрэгтэй, тийм биш эгэл гүдэг үгсээр бичихэд хүрвэл, үзэсгэлэнт залуу хүмүүс өмссөн хувцсаа тайлж чармаа нүцгэнээр хүнтэй бараадахаар очсон мэт гэж зүйрлэн өгүүлсэн байна. Тэр мөн Хайравж Гэлэгбалсанбуугийн гэгээний “бүдүүлэг тэнэг үгсийн нэр томъёогоор ижилдүүлэн дүүргэвээс ертөнцийн сул дэмий үг

бичсэнээр тийн үлмүй” (Ишбалжир, зүүлт: 9.х.4 дээд) гэсэн үгийг эш татаж, зохист аялгууны хэл нь эгэл бүдүүлгээс зайдуу яруу гоёмсог байхын чухлыг өгүүлсэн байна.

Уянгатай, жавхлантай туурвих нь уран яруу болгохын нэгэн илрэл болох юм. Түүнчлэн “туурвихын эцэст, хүлцэнгүй өчиг залбирал, буяны ерөөл бичиг тэргүүтнийг найруулах бөгөөд түүнд туурвигч мэргэн ба утга сайн, үгс нь жавхлантай ба туурвил сайн тэргүүтнийг төгсгөх хэрэгтэй болой. Бусад мэргэд ба хүний эрхт тэргүүтэнд захидал бичих тэргүүтнийг туурвихад ч, тасалсан, үргэлжилсэн, хавсарсан алимэдийг үйлдэгч, үгсийн утга барилдлага төгөлдөр болгох нь адил бөгөөд чихэнд уянгатай холбох болой” (Ишбалжир, зүүлт:10. х.55 дээд 55 доод) гэж зохиолыг утга төгөлдөр, туурвил зүй, үгс нь жавхлантай, чихэнд уянгатай туурвих хэрэгтэй гэсэн санааг дурдсан байна. Үнэндээ энд дуун ба утгын яруу сайхны чухал чанарыг өгүүлсэн юм.

Утга үнэн бөгөөд төгөлдөр байх

Ишбалжирын утгын тухай шаардлагад утга сайн, утгын барилдлага төгөлдөр байх тухай өгүүлэхээс үл барам утга үнэн байх шаардлага байдаг. Тэр зохиол туурвилд санааг урнаар илтгэх ба утга төгөлдөр байхыг шаардаж арсланы эвэр гэх шиг хуурмагаас зайлж, барилдлагагүй утгагүй, тэнэг үгсийг тэвчих хэрэгтэй хэмээжээ. Мөн Зонкаван “зарим нэгэн байхгүй үгсийг зангидан туурвисан, бусад барилдлагагүй тэнэг үгсийг дураар өгүүлсэн” (Ишбалжир, зүүлт: 11. х.2 дээд) -ийг шүүмжилсэн энэхүү үгийг ишлэн санаагаа илтгэсэн бөгөөд Хайравж Гэлэгбалсанбуугийн хэлсэнчлэн:

“Хураангуйлбаас дээд буяны садныг эс барих бөгөөд

Шунахайрлын эрхээр болсон найман номын хойноос дагасан

Сонсохуй сэтгэхүй бясалгахуй лугаа шашны үйл тэргүүтнийг

Хэр төдийхэн шамдсан ч олонход дүрс хөрөг төдийхөн болай” (Ишбалжир, зүүлт: 12. х.2 дээд) гэх үгийг эшлэн, буяны садан хуврагыг дагахгүйгээр, шунахайрлын эрхээр баярлах, олох, сайн, магтах дөрвөн хүсэхүйн зүг ба зовох, эс олох, муу, муулах дөрвөн эс хүсэхүйн зүг нийлсэн ертөнцийн найман номын хойноос дагасан хүн хэрхэн туурвисан ч олонход дүрс хөргийн төдий

хоосон юм гэж шашны ёсоо эс баримтлагчдын бүтээл туурвил нь утга төгөлдөр бус гэсэн санааг илэрхийлсэн байдаг.

Бүжгийн есөн дүрийг найруулах

Ишбалжирын бүжгийн есөн дүрийг зохист аялгууны амин ухагдахуунд оруулснаар үл барам, бүжгийн есөн дүрийг чухалчлан найруулах тухай үзэл баримтлалаа дурдсан байдаг. Тэрээр “тэр мэт үгсийн утгад гэмгүй болбоос, түүгээр алимэд өгүүлэгдэхүүний нийт бусын язгуур, үйл, эрдэм, эд алимэд болохыг үзүүлж болох тул, өөрийн чимэгт утгаар явах боловч, шүлэг мэтэд, Саж Бандидаас “үзүүргэхүй (үзэсгэлэнт), баатаргахуй (үл айх), гоо бус (үзэсгэлэнт бус), инээхүй (шог инээдэм), хатуу догшин (хүч үүсгэх), аймшигт (чанадсыг эмээлгэх, чанадсыг айлган түвэгдүүлэх), нигүүлсэхүй (энэрэнгүй), агсрахуй (оморхоглолыг дарах бөгөөд хориглох), амарлихуй ес” ба “үхэлгүйн сан”-аас наймд хураасан хэмээх лугаа есөн дүрийн амт лугаа найруулж улируулмуй хэмээсэн мэт, дүрийг харилцан эс зохицолдохыг огоорч, зохицолдуулан холбох сайн дүрт дуун, утга, нууц үгсийн чимэг тэргүүтэн үгсийн чимгийн хотол чуулганыг эс төгсгөвөөс хүний сайн биед хувцас засал чимэг эс төгссөн мэт ба хэрвээ тэр төгөлдөр болбоос, хүний сайн хувцас засал чимэглэл бүрдсэн мэт болой” (Ишбалжир, зүүлт: 13. х.55 дээд) гэж бүжгийн есөн дүрийг сайтар зохицуулан найруулбал, хүн хувцас засал бүрдсэн шиг хотол төгөлдөр болно гэжээ.

Энд онцгой дурдуштай нь Ишбалжир бүжгийн есөн дүрд бас товч тайлбар хийж, даруй дээрх хаалтад буй үгс, үзүүргэхүйг үзэсгэлэнт гэсэн, хатуу догшныг хүч үүсгэх гэж тодорхойлсон мэт, эдгээр дүрийн онцлогийг улам тодотгожээ. Энэ нь түүний бүжгийн есөн дүрийн гоо зүйн онцлогийн тухай дурдсан санаа болно.

4. Гэмгүй найруулга

Ишбалжирын утга зохиол туурвилын тухай нэгэн чухал үзэл баримтлал гэвэл гэмгүй үйлдэх явдал болно. Тэрээр утга зохиолыг төгс найруулах хэрэгцээ их байтал, өөрийн дур зоргоор үйлдвэл зүйрлэвэл үзэсгэлэнт хүүхэн өчүүхэн нэгэн сорвийн уршгаар муу хэмээн хэлэгдэхтэй адил болно гэж үздэг. “Тиймийн тулд ловон Дандин бээр утга дорой, харш утгат, нэгэн утгат, түүдрэлт ба дараалал буурсан, аялгуу буурсан, холбон найруулга дорой, завсар барилдлагаас ангижирсан, орон цаг ид заль ертөнц ба эс онолуудтай харшлах арван гэм тэдгээрийг зохист аялгуунд зохист аялгуучин бээр тэвчигдэхүй

хэмээсэн болой” (Ишбалжир, зүүлт: 14, х.4 дээд) хэмээн Ишбалжир бээр зохист аялгууны гэмийг арилгахын чухал чанарыг дахин давтан дурдсан байдаг.

Тэрбээр захидал бичгээр жишээлж “тийм бөгөөс захидал бичих ёсонд (номтгогдохууны эш)-ээс номлосон мэтээр, зөөлөн, ширүүн 2 ба бусад бас магтах ба муулахын, гайхамшигтай ба эгэл ерөндөг болсны ба айлган үйлдэхийн ба суралцагдахуун үгс тэргүүтэн, олон байсан ч онцгой зарим нэгээс гадна ерийн хэлсэн (зохиосон) үгсийн найруулга бүгд зөөлөн аялгуугаар илгээгдсэн (бичигдсэн) ба бас утга муу ба дорд ба нарийнд зохист аялгууны чимгээр зохист үзэсгэлэнт болгон үйлдэх ба утга сайн ба хялбар зохистой ч түүнтэй зохицолдоно. Тэр ч бас алимэд зохистой зохист аялгуу нь гэмээс хагацах ба илт өгүүлэх буусан адилаар чимэглэвээс, чихэнд сонсголонт бөгөөд сэтгэлийг булаахаар үл барам зохист аялгуучны алдар өргөн дуурсаж, мэргэдийн ширээнд багтах болно. Бас тэрхүү чанараар зохист аялгуу нь өчүүхэн төдий аялгууны саваас үйлдвээс мэргэдийн суудалд сууж босмуй хэмээх мэт болой” гэж зохистой бичихийн чухлыг өгүүлэв.

Энд Ишбалжир захидал бичиг доторх зөөлөн, ширүүн, магтах, муулах, гайхамшигтай ба эгэл айлган үйлдэх үгс зэрэг онцлог буюу ижил бус ур чадварыг дурдсаныг утга зохиол онцлог уран дүрслэлийг үзүүлсэн гэж үзэж болох юм. Онц заримаас гадна үгсийн найруулга нь зөөлөн аядуу байж, утга муу буюу доорд болбоос зохист аялгууны чимгээр яруу утгатай болно. Утга сайн ба зохист аялгуутай зохицолдож байдаг. Энд чимэг үг хэрэглэх нь чихэнд сонсголонт бөгөөд сэтгэлийг булаах зохист аялгуу туурвиж чадахаар үл барам мэргэдийн ширээнд сууж чадна гэж өгүүлсэн нь утга зохиол туурвил дахь алдаа дутагдлыг арилгахын чухлыг өгүүлсэн явдал болох юм.

Тэрбээр бас “тэр ч бас өөрийн бодитой байх ба өөрийн багш тэргүүтэн дэлгэрэх цагт тэдгээрийг магтах ба өөр өөрийн адил цаг бусад нэгэн бээр, атаархал, алагчлал тэргүүтэн бээр доромжлох тэр алимэдэд бас сэтгэлд итгэмжлэхгүй болоход алимэдийн сайныг өгүүлэх ба гэмийг өгүүлэх ялгамжаар, хойно нь гарах мэргэд хэлбийгүү мушгиагүйгээр ялгаж болох бөгөөд, бас Сажа бандида бээр (эрдэнэнийн үгс бээр найруулах хэрэгтэй, эгэл чулуу алдаршсан ч хэн худалдан авах вэ) хэмээсэн мэт ч байх болой” (Ишбалжир, зүүлт: 16, х.55 доод) гэж өмнөх мэргэдийн туурвисныг

хэрхэн зөвөөр ялгаж, зохиол туурвилдаа хэрэглэх, эсхүл зохиолдоо магтах буюу шүүмжлэх тухай санаагаа дурджээ. Багш тэргүүтнээ магтах нь туурвилын ердийн агуулга мөн. Гэтэл зарим үед зарим дээд хүмүүст атаархах алагчлалтай сэтгэл үүсгэхээс болж итгэхгүй, биширэхгүй байдал гарч, сайныг өгүүлэх ба мууг өгүүлэх ялгамжаар хожмын мэргэд ялгаж болно. Зохиол туурвилд эрдэнэ мэт сайн үгсийг хэрэглэх хэрэгтэй, харин эгэл юмсыг хэрэглэсэн бол үнэд хүрэхгүй чулуу шиг болно гэжээ. Энд хэлбийж мурийлгүйгээр магтах буюу муулах зохиолоо бичих хэрэгтэй гэсэн үзэлт илэрч байна. Мөн сайн найруулгатай зохиол, туурвил зохиох ёстой гэсэн үзэл санааг илэрч буйг дурьдах нь зүйтэй.

Гурав. Үргэлжилсэн зохиол бичих тухай шаардлага

Ишбалжир зохиол туурвих тухай зарчмын шаардлагыг гаргаснаар үл барам, зохиолыг хэрхэн бичих тухай өөрийн үзэл баримтлалаа дэвшүүлсэн байдаг. Олон мэргэд яруу найраг хэрхэн туурвих тухай шаардлагыг дурдаж байсан бол Ишбалжир зөвхөн яруу найраг төдий биш, үргэлжилсэн үгийн зохиол бичих шаардлагыг дурдсан байдаг. Энэ нь түүний үргэлжилсэн үгийн захидал бичих ба намтар бичих тухай үзэл баримтлалаар илэрч байна.

1. Захидал зэрэг үргэлжилсэн зохиол найруулах шаардлага

Ишбалжираас шүлэглэсэн захидал бичгийг хэрхэн зохистой аргаар чимэх тухай дурдсанаар үл барам үргэлжилсэн хэлбэрийн захидлыг хэрхэн туурвих талаар өгүүлсэн байдаг. Үүнийг үргэлжилсэн үгийн зохиолыг туурвих шаардлага гэж үзэж болно.

Тэрээр “түүнээс шүлэглэсэн захидал бичгийг зохист аялгуу унжид нэрээр чимэглэсэн чихний тэжээл ба сэтгэлийн тэжээл зохиохыг хүссэн зохист аялгууны толины чимгийн үлгэр өгүүлэхүй өчүүхэн төдий илт өгүүлэхүй сэлтийг би бээр ч тусгайд \ангид\ зохиох тэргүүтэн мэтээр үйлдэхүйд” (Ишбалжир, зүүлт: 17. х.6 доод) хэмээн шүлэглэсэн захидал зохиолыг зохист аялгуу болон унжид нэрээр чимэглэн, чихэнд сонсголт, сэтгэлийг тэжээх зохист аялгууны үлгэр өгүүлэхүй үйлдэхүй зорилгын талаар өгүүлсэн байдаг. Мөн “энд нь гол болгон үргэлжилсэн үгийн үйлдэх ёсныг алхдал \алхам, явдал\ төдийхөн өгүүлэхүйд” (Ишбалжир, зүүлт: 18, х.6 доод) хэмээн үргэлжилсэн үгийн зохиолыг

хэрхэн туурвих тухай өгүүлэхээ: “дүрст чимэг мэт үйлдвээс мэт, шиг, адил тэргүүтний үүднээс үлгэр ба утгыг эс хаацайлахаар алимэд утга түүнийг тэр үлгэрийн орон \байдал\ дүрсэд зохиох бөгөөд, тэр ч бас \Огоод хурахуй\ мэтэд хөрөнгө үндэс модны салаа буюу цэцгийн үр есөн хүслийн соёрхол тэргүүтэн нь утгын хувийг зэрэг дараалан найруулах мэт бөгөөд, наран саран сэрж огторгуй газар дэлхий уул, сэтгэлийг хангагч эрдэнэ, эсэрваа, ваанчиг, бишнү, арслан тэргүүтний эрдмийн хувийг найруулах бөгөөд түүнчлэн самади лугаа адил сайтар ухахуй үлгэрийн чимэг, дууны чимэг тэргүүтнийг ч найруулж, ширүүн ба нууц үгс тэргүүтнийг зарим үест нууц үгсийн чимгийг ч найруулах зохистой болохуй” гэж үргэлжилсэн үгийн зохиолыг хэрхэн чимэглэх, ямар агуулгыг бичих тухай өгүүлэв.

Энд үргэлжилсэн үгийн зохиолыг туурвихад дүрстийн чимгийг хэрхэн үйлдэх самадын эрдэм ба самадын сайтар ухахуйн чимэг дууны чимэг, нууц үгсийн чимэг зэргээр ч чимэглэн бичиж болно гэж үзсэн байна. Үүнд дүрст чимгийг найруулахад “мэт, шиг, адил” гэх зэргийн үгийг хэрэглэхгүй ч тэдгээр утгыг багтаасан, үлгэр ба утгыг хаацаалахгүйгээр ямар нэгэн утгыг түүний үлгэрлэх орны дүрсэд оршуулан үйлдэнэ гэж дурдсан юм.

Бас “Огоод хурахуй найлзуур модон (галбарагчаа модон) гэх зохиолд хөрөнгийн үндэс болох модны салаа, цэцгийн үр, есөн хүслийн соёрхол тэргүүтэн утгыг бичиж байхыг эш татаж нар сар, огторгуй, газар, дэлхий, уул гэх мэт байгалийн өнгө үзэмж жич тэдний тус тусын гайхамшиг эрдэм сэтгэлийг хангагч, эрдэнэ эсэрваа, ваанчиг, вишнү, арслан тэргүүтний эрэм чадлыг бичнэ гэж чухалчилсан байна.

2. Намтар зохиол туурвил зүйн бодит шаардлага

Ишбалжир “Өөрийн намтар”-гаа намтар бичсэн шалтгаанаа бичихийн дашрамд зарим хүмүүсийн бичсэн зүй бус явдлыг шүүмжилж, өөрийн зохиол бичсэн хувийн үзэл баримтлалыг өгүүлсэн нь зохиолын шаардлага байсан гэж дүгнэж болно. Үүнийг туурвигчийн ёс суртахуун, агуулгын шаардлага зэргээр шинжилж болно. Зохиогчийн тухай өгүүлэх намтар туурвигч нь “дээдэд атаархаж доодод хилэгнэх”, “өөрийгөө магтаж бусдыг муулах доромжлох”, “хоосон үг өгүүлэх”, “богдос буюу хутагтаар овлох”, “бүхнийг мэдэгчээр овлох”, “шашин амьтны тусын төлөө хэмээгээд өөрийн тусаа эрэх”,

“хуурмагаар өгүүлэх”, “шашны сахилтай харшсан ч шашны ёсон гэж хуурмаглах”, “дөлгөөн зөөлөн хуурмаг үгээр бусдын толгойг эргүүлэх”, “аманд ном номлож, сэтгэлд арга заль бясалгах” (Ишбалжир, зүүлт: 20. х.1-2 дээд) зэрэг нь намтар зохиол туурвихад тэвчих зүйлс даруй мөн.

Дараа нь ямар агуулгыг бичиж болох буюу эс болох тухай өгүүлсэн байна. Хүнд таашаагдаггүй ёс зүйгүй явдлыг эс бичих, эртний хувилгаан мөн гэж хуурмаглаад би урьд төрөлдөө үүнийг үйлдэж, тэрийг зохиосон гэж хий хоосноор дурдатгал бичихийг тэвчих, нууц тарни увдистай гэж хүнийг мэхлэх, хуурмаг юм эс бичих, гэмээ нуугаад эрдмээ л бичихийг цээрлэх зэрэг олон шаардлага дурджээ. Онцгойлон “зүггүй улс орноор хэссэн яриа, өнөө насанд тэр оронд хэсэж, энд оршсон, тийм мэтийн үйл явдал үйлдсэн хэмээх элдэв зүйлийн цуурай, шуугианыг дураар эс ярих (Ишбалжир, зүүлт: 21. х.6 дээд) гэж элдэв зүйлийн худал хуурмаг шуугиан мэт юмыг эрий хурийгүй дураар зохиохгүй гэжээ. Бас өмнө хойнох нь зохицохгүй, утга бүдүүлэг болбол сайн зохиол биш гэж үзжээ. Үүнийг нөгөө талаар намтар зохиол мэтийн уран бүтээл нь уран яруу бөгөөд заавал үнэн бодитойг баримтлах хэрэгтэй, бодит ахуйг харгалзах үзэх хэрэгтэй гэсэн санааг агуулсан хэмээн үзэж болно.

Ишбалжир намтар зохиол нь ямар байвал зохих тухай үзэл баримтлалаа дурджээ. Доорх хэдэн бадаг шүлгийг үзвэл:

“Бусад зарим (таван зуут) -ын доод явдлын үүлэн чуулганаас

Бусчирлан хуурмаглан хувилсан эгэлийн гялбаа ургасан солонго

Бульхай олон тэнэгчдийн нүдний хараанд үзэсгэлэн болсон ч

Болмоор хэн нэгэн оюун төгөлдөр хүмүүн бээр оройн чимэг болгох буй

Доод явдлын үндсээ газрын доор нууж

Дээд найман баглаа номыг дээр нь тавьсан

Дэмий номтны гялбаа бээр бүрхсэн ч газар мөр бээр хоосон

Дэндүү хөгшин гадил мэт өөрөөр ч зүрхгүй

Нааш үзэхэд өөрийн гялбаа чанараа гайхуулан буурахуйд

Ялгуун байх гэмийг үгүй хэмээн ярихгүй

төгөлдөр дээд хэлээр

Шидмээр шахамдуулсан ч эсэрваагийн эгшиг дуун бус гэж

Шударга голч ухахын яруу дуу үүнийг авав”
(Ишбалжир, зүүлт: 22, х.6 доод 7 дээд)

хэмээн хуурмаг эгэл зохионгуй ба хоосон зохионгуйг тэвчиж, байх гэмийг үгүй гэж хэлэхгүй, муу дууг эгшиг дуун гэж хэлэхгүй шударга голч овроор намтраа бичлээ гэж бичсэн байна. Энэ нь намтар зохиол бичихэд төв голч ёс суртахуун байх хэрэгтэй гэсэн үзэл болно. Таван зуут гэж бурхны ном ертөнцөд дэлгэрэхийн хамгийн эцсийн таван зуун оныг хэлж, энэ үед хүмүүсийн уруудал доройтлын байдал илт болох гэнэ. Хуурмаглан зохион бичсэн эгэл намтар зохиол нь солонго шиг үзэсгэлэнтэй байсан ч, тэнэгүүдэд үзэсгэлэнтэй харагдахаас биш, жинхэнэ оюун төгөлдөр хүн түүнийг ойшоохгүй гэжээ. Бас муу явдлаа нуугаад номын баглаагаар далдалсан ч, эцэстээ хоосон юм гэж үзжээ.

Тэр бас:

“Тиймийн тулд машид цагаан үйлээр цог учралыг олж

Дээд ялгуусны шашинтай сайтар бараадсан номын явдал ёсыг

Өөрт эс нуусан зарим үйл явдлыг

Үнэхээр гүтгэн муушааж тэвчээд тохиосон нь энэ мэт болой” (Ишбалжир, зүүлт: 23. х.2 дээд 2 доод) хэмээн намтар зохиол бичихэд, номын явдал ёсыг хэрхэн бичих бөгөөд зарим үйл явдлыг нуулгүй гүтгэн муушаах буюу тэвчиж байгаад зохиох гэсэн үзэлт дурджээ.

3. Зохист аялгууны чимгийн аргыг үргэлжилсэн биед хэрэглэсэн ур маяг

Ишбалжир бол зохист аялгууны чимгийн арга зарчмын шүлэг найргаар үл барам үргэлжилсэн үгийн зохиолд ч хэрэглэн дадсан эрдэмтэн юм. Харин бусад эрдэмтэн иймэрхүү оролдлого хийсэн нь тун ховор. Тэрээр “Өөрийн намтар”-таа утгын гучин таван чимгийн үүднээс өөрийн явдал ёсоо бичсэн нь зохист аялгууны чимгийн аргын үргэлжилсэн биеийн зохиолд хэрэглэсэн тод жишээ болжээ.

Тэрбээр “Өөрийн намтар”-таа дотроо зохист аялгууны эс завсардсан хос төгөлдөр чимгийн аргыг хэрэглэж үргэлжилсэн үгийн зохиолыг бичсэн байна.

“Тэр мэт чөлөөний шүтээн (хүмүүн бие)-д толгой сүүл хэмээн өгүүлэх мэтээр, өөр бусдын төлөвлөгөө бүтэх ёсныг энд хураангуйлбаас: Сайн сайн цагаан (цагаан буяны) үйл үйлээс бүтэхийн сайн хүний биед ариун ариун шагшабадын анхилам анхилам үнэр лүгээ төгөлдөр бөгөөд шулуун шулуун сахил ба цэвэр ариун сахилд оршсон мэт, олон олон ухааны орны усан сан (далай)-д дэнслэн дэнслэн зовох сэтгэлээр оршоод, тодорхой тодорхой оюунаар гүн гүн утгын зүрхэн эрдэнийг авахын тусад бат бат шамдал ба ядрал ядралын бэрхийн чуулганаар, мэргэн мэргэн богдос тус тусаас яруу яруу эшийн шашны номыг дуун баригчийн балгад балгад бээр нарийлаг нарийлаг сонсоод, тэрхүү утгыг хангинатал хангинатал мэргийн тулд хурц хурц эш ухааны тэмцэхүй бээр сэжгийг таслаад дахин дахин сэтгэж, түүгээр бүрхэн бүрхсэн сэжгийн харанхуйг алимэд алимэдийг тодорхойлон, буян буяны эшийн алимэд утгыг гайхуулалгүйгээр нуугаад, цагаан цагаан сэтгэлээр чухалчлан аваад, сайн сайн, сүсэг тэргүүтэн эрдмийг түргэн түргэн олохын тусад эцэж туртал шамдан шамдан үйлдээд, хожим хожимд завсар завсарт өндөр өндөр ширээний дээр зөөлөн зөөлөн дэвсгэрт саатаад, шавийн чуулганд зохимжтой зохимжтой эш ухаан увдисыг мөшөөн мөшөөн царайн гялбаагаар уриад, ариун ариун хоолойн мөрөөс хялбар хялбар тархаасан бөгөөд хүчир хүчир хэмээн эс орхиж, зохистой зохистой тохитой дэлгэрүүлэн хураангуйлж, яруу яруу номлоод, бүрэг бүрэг оюуны буруу бодлого хямран хямран булингарыг тодруулаад, номын гэрлийг ихээс их цацруулах бас үес үест мөр мөр гүйдэл бээр зүг зүгт хэсэхүйд зүрхнээс нигүүлсэнгүй нигүүлсэнгүй асрахуй асрахуй их ихээр хувь төгөлдөр өөр өөр бээр хүсэн хүсэн хүсэл юун мэтчилэн ханаж чадахын үес, бишрэл төгс хүний сэтгэлийн харанхуй бүрэнхий бодонгуйрал алмайрлыг арилгахын төлөө би бээр хоромхон ч амрахгүй номын сайн хаврыг дэлгэрүүлэхийн тулд худал хуурмаг төдийхөн ч бус дээд сайн номлол алимэдийг өнөд тэвчсэн үгийн баяр хуримыг бэлдэхийн үес тус тусын сэтгэлийн эрдмийг баригч (газар дэлхий)-д эс сүсэглэх тэргүүтний гэмийн хир буртгийн гэрийн эзэн ба түүдрэлийн энхэл донхолгүйд хар бор буруу атхагаас ангижран тэгш сацуугаар, өчүүхэн бутархай буянаас дээшид бээр үр хөрөнгийг татгалзалгүй нууснаас хишгийн чуулганы машид ягч ойн дундад доорд бүдүүлэг, худал хуурмаг залирхаг хулжингүй галбарагчаа модон мэндлэн ургахад өчүүхэн төдий бус илт өндөр салааны уужим өргөн үзүүрт бутархай шингэн бус магад

сайн найгасан навчис гараад, газар мөрт цэцэг мяралзан мөшийснөөс гарсан бат амгалангийн есөн хүслийн үрийг эдлэхийн тусад төгс хувьт зөгий бээр сайн номлолыг үнгэнэн жингэнэн дуурсгаад алжуу залхуу, хааш яайш бус хичээл шамдал бээр түүнд тэвдрэн эргэлдээд, хэсэг бусад төдий бусын сайн номлолыг сайтар сонсохын оронд билгээр орныг хэрхэн олохыг үзээд ертөнц ба ертөнцөөс хэтэрсэн сайн буяныг олохын тусад яаран яаран сандарч ялгуусан ба ялгуусны хөвүүний газар мөрт оршоод, амгалангаас амгаланг хүсэхийн тулд мөнх мөнх бусын ялгалыг ялгаж үнэн хоёр (хоёр үнэн) хоёргүйг шинжлээд сайн чуулган чуулган хоёрын хязгаарт хүрч, хоцролгүй биетний бат амгалангийн баярт хуримд цэнгүүлэх болбоос зуунд зохисгүй болой хэмээн хүсвэй” (Ишбалжир, зүүлт: 24, х.60 дээд 61 доод)

Энэ хэсэг уран найраглалыг өнөө цагийн уран найраглал буюу задгай шүлэг гэж нэрлэж болно. Энд эрдэнэт хүний биеийг олсны дараа шашны мөрт орж, ариун сахилыг сахиж, эрдэм ухааныг цөхрөлгүй шамдан эзэмшиж, олон багшийн эш номлолыг анхааран сонсож, номлохуй, тэмцэхүй, туурвихуй, сонсохуй, сэтгэхүй, бясалгахуйн үйл үйлдээд мэргэдийн ширээнд саатаж, үргэлжлэн буяны чуулган ба бэлгэ билгийн чуулганыг халшралгүй үйлдэж шашны ном дэлгэрүүлэн дуурсгаад тус амгалан олж амьтныг баясгаж, үзэгдэл ба мөн чанарыг ялган, хоёр чуулганы туйлд хүрч, амьтан бүхэнд бат амгалангийн баяраа хурим үйлдэх ийм нэгэн явдал өгүүлжээ. Энэ нь Ишбалжирын хүсэл бөгөөд мөн ч бусад шашинтныг мөрдвөл зохих хүсэл шаардлага мөн.

Энэ нэгэн багахан хэсэгт эс завсардсан хос төгөлдөр чимгийг дөчин есөн удаа хэрэглэж, санаагаа уран яруу илтгэн гаргасан нь үнэхээр гайхалтай. Үүнээс гадна Төвөдийн давталтын шинжтэй тэмдэг үг ба дайвар үгийг олон хэрэглэж, улам амьдлаг утга нэмж, олон дүрслэхүүнт зураглалыг нэмэгдүүлсэн байна.

Судалгааны үр дүн:

“Дотоод утгын нэр томъёоны зарим нэгэн сэжигтэй асуултад хариулж бичсэн, маш цагаан Сугар гараг хэмээгдэх оршвой”-д үргэлжилсэн зохиолд хос төгөлдөр чимгийг хэрэглэсэн жишээ бий. “Тэр мэт мэргэд мэргэд олон оршсон алимэд алимэд бүхний явдал ариун ариун гурван үүдийн эелдэг эелдэг ёс дээд дээд сайн төгөлдөр олон олон буяны садныг хураасан их усны сан (далай)-д оршвой. Олон олон төгөлдөр сонссон алимэд

бээр сайн цагаан цагаан өдлөгтөр бээр бат бат бишрэлийн найруулгын уламжлалыг найруулсан их онгоцонд шүтээд, чухал чухал асуултыг яруу яруу гэмгүй их дарцгийн нандин гэр бээр сэжлэн сэжлэн хөдөлгөөд тодорхой тодорхой эш шалгадаг ба гүн гүн тийн арилсан ухааныг барьж барилдсан захидал бичгийн элчийг дахин дахин учруулбаас, үүнээс ч ба бүрэн бээр баяслаар сул бутархай хааш яашаар бус салхинаар хураагаад татгалзалгүй машид баяслын огторгуйн зааны чуулган нь дэлбэлзэн хөлбөрөх мэт хариултын шинжлэлийн бэрх дохиог халтар бултар хялбархан дөхмөөр уях бус” (Ишбалжир, зүүлт:25. х.98 доод) гэж хос төгөлдөр чимгийг сайтар хэрэглэснээр, санаагаа нэн яруу илтгэж чадсан юм. Энд Аруухан мэргэд цугласан чуулганы далайд, олон сонссон мэргэд бээр буяны цагаан үйлийн хүслээр сүсэг бишрэлийн их онгоцонд сууж, чухал асуултыг яруу үгсээр хариулаад тодорхой бөгөөд гүн утгат эш онол ухааны захидал бичгийг илгээж байгаа байдлыг нүдэнд үзэгдэм амьдлаг дүрслэгдэхүүнтэй уран яруу ураглан дүрсэлсэн байна.

ДҮГНЭЛТ

Ишбалжир бол Төвөд ба Монгол эрдэмтдийн дотор үргэлжилсэн үгийн зохиолд хос төгөлдөр чимэг зэргийг хэрэглэсэн цөөн эрдэмтний нэг мөн. Үүнээс гадна, түүний “Өөрийн намтар” нь зохист аялгууны чимэг ба илт өгүүлэхүйгээр сайтар чимэглэгдсэн уран яруу намтар туурвил зүй болох юм.

Эцэст нь дүгнэж хэлбэл, Ишбалжирын уран зохиол туурвихуйн үзэл баримтлал нь зохиогчийн хэв чанар, зохиол туурвилын нийтлэг зарчим жич үргэлжилсэн үгийн зохиол туурвилын шаардлага гэх хэдэн зүйлээс бүрдэж, өөрийн гэх онцлог шинжээр ялгарч байдаг юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Ишбалжир., “он т-бус” Номын явдлын өчүүхэн хураангуй, сайн галавын гэтэлгэх мөр оршвой. Төвөд судрын бар.

Ишбалжир., “он т-бус” Сүмбэ хамба Занаашир Бхутиваар олон их голуудаас хурааснуудын гарчиг, тунгалаг нуурын дүрс оршвой”, Төвөд судрын бар.

Ишбалжир., “он т-бус” , Хамба эрдэнэ Бандида хэмээн алдаршсаны явдал ёсныг өгүүлсэн дуун баригч (чихэн)-ийн тэжээл хэмээгдэх оршвой.

Ишбалжир., “он т-бус”. Захидал бичиг тэргүүтний тийн агуулал, шинэ оюутны баяр хуримын үүдийг нээхүй. Төвөд судрын бар.

Ишбалжир., “он т-бус” Дотоод утгын нэр томьёоны ухааны голын зарим нэгэн сэжигтэй асуултад хариулсныг нэгэн зүгт бичсэн, маш цагаан сугар гараг хэмээгдэх оршвой. Төвөд судрын бар.
19. Ишбалжир., “он т-бус” Захидал бичиг тэргүүтний тийн агуулал, шинэ оюутны баяр хуримын үүдийг нээхүй. Төвөд судрын бар, 6 доод- 7 дээд.